



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 35

Дархан

Зарим гудамжнуудын нэр, байршил,
хил заагийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалт "Гудамж талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам батлах тухай" Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дархан сумын зарим гудамжнуудын нэр, байршил, хил заагийг нэгдүгээр хавсралтаар, Цогцолбор газар, нэрэмжит талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 17 -ны өдрийн
35 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт




ДАРХАН СУМЫН ТӨВ ГУДАМЖНУУДЫН
НЭР, БАЙРШИЛ ХИЛ ЗААГ

№	Гудамжны нэр, байршил, хил зааг	Гудамжны нэр	Зай /м /
1	Аймгийн Засаг даргын тамгын газраас хойшоо "Барилгачдын өргөн чөлөө"-ний замын уулзвар хүртэл.	Бурхантын гудамж	1847,9
2	Хуучин хорооллын 39 дугаар байрны урд талын замын уулзвараас зүүн тийш АШУҮИС-ийн замын уулзвар хүртэл.	Жаргалантын гудамж	659,8
3	АШУҮИС-ийн ар талын замын уулзвараас хойшоо шинэ хорооллын 27-р байрны зүүн хойд замын уулзвар хүртэл.	Хөдөлмөрийн баатар Г.Тэгшжавын нэрэмжит "Эрчим хүчний гудамж"	1033,5
4	"Номин" худалдааны төвийн зүүн талын замын уулзвараас Дархан-Улаанбаатарын чиглэлийн замын уулзвар хүртэл.	Олимпийн гудамж	1629,7
5	Залуучууд театр руу эргэдэг замын уулзвараар хойшоо Дархан их дэлгүүрийн баруун Ардын өргөн чөлөөний зам хүртэл.	Тамирчдын гудамж	385,0
6	Хуучин хорооллын "Үйлчилгээний төв"- ийн зүүн урд уулзвараас баруун тийш 4 дүгээр цэцэрлэг хүртэл.	Хотын дарга асан Ч.Сүрэнгийн нэрэмжит "Багачуудын гудамж"	572,6
7	"Киви" зочид буудлын уулзвараас зүүн хойш "Нүүдэлчин" эмнэлгийн зүүн уулзвар хүртэл.	Архитектор Б.Чимэдийн нэрэмжит "Бууралын гудамж"	453,2
8	Аюулгүйн тойргоос зүүн тийш шинэ хорооллын 27 дугаар байрны зүүн уулзвар хүртэл.	Үндэсний эрх чөлөөний гудамж	1677,4
9	16-н давхарын уулзвараас "Дархан хүнс" ХК-ийн арын уулзвар хүртэл.	Ардын өргөн чөлөө	4353,1
10	"Мөнгөн хөөс" авто угаалгын газрын урд замын уулзвараас баруун урагш Онцгой байдлын газар хүртэл.	Генерал Д.Бавуугийн нэрэмжит "Эх орончдын гудамж"	446,0
11	Вокзал руу эргэдэг замын уулзвараас баруун тийш Барилгачдын өргөн чөлөөний шинэ замын уулзвар хүртэл.	Төр нийгмийн зүтгэлтэн Ю.Цэдэнбалын нэрэмжит "Хуульчдын гудамж"	904,9
12	Вокзалын уулзвараас хойшоо "Дархан" дээд сургууль хүртэл, Дархан дээд сургуулиас "Турк" сургуулийн зүүн талын замын уулзвар хүртэл.	Давхрын өртөөний гудамж	793,4
13	"Россия" зочид буудлын зүүн хойд талын уулзвараас баруун тийш Төмөр замын 34 дүгээр байр хүртэл.	Ган замчдын гудамж	295,5
14	"Буян" захын баруун талын замын уулзвараас баруун тийш 15 дугаар сургууль хүртэл.	Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит "Худалдааны гудамж"	295,6
15	"Дархан хүнс" ХК-ийн урд талын замын уулзвараас баруун тийш "Ариун амгалан" ХХК-	Атарчдын гудамж	498,7

	ийн урд замын уулзвар хүртэл.		
16	"Шунхлай" ХХК-ийн ШТС-аас баруун тийш наадмын талбай хүртэл.	Наадамчдын гудамж	1464,6
17	Шүүх руу эргэдэг замын уулзвараас хойшоо "Шунхлай" ХХК-ийн ШТС хүртэл.	Улаан-Үд хотын нэрэмжит "Залуусын гудамж"	1455,4
18	АШУУИС-ийн хойд талын замын уулзвараас зүүн тийш ТИС хүртэл.	Оюутны гудамж	721,2
19	16-н давхарын урд замын уулзвараас зүүн урагшаа хуучин нисэх хүртэл.	Мангиртын гудамж	1905,5
20	"Хүслийн хотхон"-ны зүүн хойноос Дархан захын зүүн замын уулзвар хүртэл.	Барилгачдын өргөн чөлөө	2900,4
21	"Оюуны ирээдүй" цогцолбор сургуулийн урд замын уулзвараас зүүн хойшоо Барилгын өргөн чөлөөний замын уулзвар хүртэл.	Комиссар Д.Пэлжээгийн нэрэмжит "Хөгжлийн гудамж"	457,1
22	Аюулгүйн тойргоос Дархан-Улаанбаатарын замаар урагшаа Төмөрлөг руу эргэдэг замын уулзвар хүртэл.	Ардын хувьсгалын өргөн чөлөө	6626,3
23	"Нар хажид" сүмийн уулзвараас баруун тийш 2 дүгээр хорооллын голоор хойшоо Олимпын гудамж хүртэл.	Дархан Нэхий ХК-ийн нэрэмжит "Нүүдэлчдийн гудамж"	712,2
24	АУИС-ийн хойд замын уулзвараас үйлдвэрийн район руу давдаг замаар Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замын уулзвар хүртэл.	Үйлдвэрчний гудамж	4602,0
25	Дархан захын зүүн урд шинэ замын уулзвараас хойшоо Дархан-Сэлэнгийн замын уулзвар хүртэл.	Зүүн дэнжийн гудамж	1631,2
26	16-н давхарын уулзвараас зүүн тийш УГТХ, урагшаа Мангиртын замын уулзвар хүртэл.	Хүрээлэнгийн гудамж	1099,1
27	Наадмын талбайн зүүн уулзвараас Хараа голын гүүр хүртэл.	Хараагийн гудамж	1432,0
28	Төмөр замын ДЕПО-ийн зүүн талын замын уулзвараас хойшоо Петровис ШТС хүртэл.	Улаан толгойн гудамж	1773,0

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 17 -ны өдрийн
35 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ДАРХАН СУМАНД БАЙРЛАХ ЦОГЦОЛБОР ГАЗАР, НЭРЭМЖИТ ТАЛБАЙ
ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН БАЙРШИЛ, ХИЛ ЗААГ

№	Цогцолбор газар, нэрэмжит талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн нэрс	Байршил, хил зааг	Талбайн хэмжээ /м ² /
1	Найрамдал талбай	“Залуучууд” театрын өмнөх талбай.	11586
2	“Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн	Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замын зүүн талд.	387020
3	“Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн нэрэмжит талбай	“Номин худалдааны төвийн баруун хойд талд	5500
4	Бурхан багшийн сэрэг дүр цогцолбор	Аюулгүйн тойргийн баруун талын толгой	3147
5	Морин хуур хөшөөт цогцолбор	Аюулгүйн тойргийн зүүн талын толгой	14489
6	Дархан – 50 цогцолбор	“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ийн урд талд.	32372